



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/154

Мандалговь

Цахим уралдаан зохион
байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 39.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Соёлын өвөө хамгаалцгаая” аяны хүрээнд зохион байгуулсан “Соёлын өвийг өвлөн уламжлагчдаараа бахархацгаая” цахим уралдааныг удирдамжийн дагуу зохион байгуулсугай.

2.Цахим уралдаанд соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг оролцуулан олон нийтэд сурталчлан , тэднийг алдаршуулах ажлыг цахимаар зохион байгуулахыг хэвлэл мэдээллийн ажилтан Л.Батсугир, багийн засаг дарга, нийгмийн ажилтнуудад даалгасугай.


3.Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 240.000 төгрөгийг засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн), ня-бо (О.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ

Сайнцагаан сумын Засаг даргын
2022 оны 10 сарын 25 ний өдрийн
1157 тоот захирамжийн хавсралт



**“СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧДААРАА
БАХАРХАЦГААЯ” ЦАХИМ УРАЛДААНЫ ТӨСӨВ**

№	Шагнал	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Дурсгалын зүйл	30.000	3	90.000
2	Өргөмжлөл	-	-	-
3	Ном	50.000	3	150.000
Нийт үнэ 240.000				